

БНМАУ-ЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ ЯАМНЫ
САЙДЫН ТУШААЛ,
УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1987 оны 8 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 179/238

Улаанбаатар
хот

Элэг, цөсний архаг өвчтэй хүүх-
дийн сувилал байгуулах тухай

БНМАУ-ЫН Сайд нарын Зөвлөлийн 1987 оны 43, Хөдөлмөр, нийгэм хангамжийн улсын хорооны 1987 оны 91 дүгээр тогтоолуудыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүлийг хамгаалах яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Халдвартын улсын диспансерийн элэг цөсний архаг өвчтэй хүүхдийг эмчлэх тасгийг Улаанбаатар хотын элэг, цөсний өвчтэй хүүхдэд зориулан 1987 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн биеэ даасан сувилал болгон Улаанбаатар хотын Эрүүлийг хамгаалах газарт харьяалгуулсугай.

2. Улаанбаатар хотын элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувиллын дүрэм, үйл ажиллагааны журмыг 1, 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Улаанбаатар хотын элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувилалыг зохион байгуулалт, арга зүй, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Халдварт өвчиний ачагаах улсын клиникин төв эмнэлэг /н.Сүх/-т даалгасугай.

4. Тус тасгийн үндсэн ба эргэлтийн хөрөнгийг 8 дугаар сард багтаан Улаанбаатар хотын Эрүүлийг хамгаалах газарт балансаас балансад шилжүүлж өгөхийг Эрүүлийг хамгаалах яамын орлогч сайд Н.Нямдорж, хотын эрүүлийг хамгаалах газар /н.Бямбаа/-т даалгасугай.

~~хөтөн АДХ-ын 161~~
5. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийг эмчлэх тасгийг өргөтгэн биеэ даасан сувилал болж байгаатай холбогдуулан уг сувиллын төсөв, орон тоог зохих журмын дагуу хянан баталж санхүүжүүлэхийг Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хэлтэс /н.Гонгор/. Эрүүлийг хамгаалах газар /н.Бямбаа/-т даалгасугай.

БНМАУ-ЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГАА-
ЛАХ ЯАМНЫ САЙД

Ч. ЦЭРЭННАДМИД

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

С.МОНХЖАРГАЛ

БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах
яам, Улаанбаатар хотын АДХ-ын
гүйцэтгэх захиргааны 1987 оны
07/09/1987 тоот тогтоолын
I дүгээр хавсралт

ЭЛЭГ, ЦӨСНИЙ АРХАГ ӨВЧТЭЙ ХҮҮХДИЙН
УЛААНБААТАР ХОТЫН СУВИЛЫН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувилал нь вируст гепатитын гаралтай архагшилт, даамжирах төлөвтэй буюу элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийг хүлээн авч сувилан эрүүлжүүлэх, эмчлэн сэргийлэх биеэ даасан нэгж байтууллага-хуулийн этгээд мөн.

2. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувиллын үндсэн зорилт нь вируст гепатитээр өвчилж, хэвтэн эмчлүүлсний дараа бүрэн өдгөрээгүй ужиг хэлбэрт шилжих, элэг, цөсний архаг үрэвсэл нь идэвхтэй хэлбэрт орохос урьдчилан сэргийлэх, сувилан эрүүлжүүлах, энэ талаар гарсан азагаах ухааны ололт амжилт, тэргүүн туршилага, шинэ санаачилгыг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлж, эмчилгээ үйлчилгээний ажлын чанарыг дээшлүүлэхэд оршино.

3. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувилал нь Улаанбаатар хотын Эрүүлийг хамгаалах газрын шуд удирдлага. Хадвартын улсын диспансерийн мэргэжлийн удирдлагын дор үйл ажиллагаагаа явуулна.

4. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувилал үйл ажиллагаандаа БНМАУ-ын үндсэн хууль, эрүүлийг хамгаалах хууль, хууль тогтоомжийн бусад акт. Эрүүлийг хамгаалах яам, газар, хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны шийдвэр, энэ дурмийг удирдлага болгож, социалист хууль ёсыг сахин бэхжүүлэх явдлыг хангана.

5. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувиллыг Улаанбаатар хотын эрүүлийг хамгаалах газраас томилсон ерөнхий эмч толгойлж, сувиллын өмнө тавигдсан уүрэг зорилтыг ханган биелүүлэх ажлыг хотын эрүүлийг хамгаалах газрын өмнө хариуцна.

6. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувиллын ерөнхий эмч хууль тогтоомжид нийцүүлэн эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал заавар гаргаж, түүнийхээ биелэлтийг хангана.

7. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувилалд тус сувиллын уүрэг зорилтыг ханган биелүүлэхтэй холбогдсон гол чухал асуудлыг хамтран хэлэлцэж байхын тулд зөвлөх эрхтэй захиргааны зөвлөл ажиллана. Захиргааны зөвлөлийг ерөнхий эмч толгойлно.

8. Элэг цөсний архаг өвчтэй хүүхдийн сувиллын зохион байгуулалт срон тоо, төсвийг хот, районы АХ-ын чуулганаар хэлэлцүүлэн батлуулж ажиллана.

9. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувилал тогтоосон журмаар хийсэн албан бичгийн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2.

ХОЁР. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувиллын үүрэг

10. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувилал нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ.

а/сувилал нь элэг, цөсний архаг үрэвэлтэй хүүхдийг эмчлэн сувилах бух талын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

б/вируст гепатитээр өвчилсөн хүүхдийн эдгэрэлтийн байдад судалгаа хийж, ужигралтыг бууруулах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ;

в/тус сувиллын сувилгаа, эмчилгээний үр дүнгийн талаар диспансер, райондын хүүхдийн эмч наарт жилд 2 удаа тайлангаа тавьж санал солилцож ажиллана.

г/вируст гепатитээр өвчилсний дараах эмчилгээ, сувилгаа, дэглэмийн талаар хүүхдийн эмч наарт мэргэжлийн зөвлөлгөө ажне.

д/оношлогоо, эмчилгээ, сувилгаа, үйлчилгээний ажлын чанар, зохион байгуулалт, ажлын цагийн ашиглалтыг сайхруулах, хөдөлмөрийн социалист сахилга, дэг журмыг бэхжүүлэх, социалист уралдааныг өрнүүлэх, тэргүүн туршилагыг нэвтрүүлэх, дотоод нөөц бололцог илрүүлэн ашиглахтай холбогдсон ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ;

е/сувиллын жил, таван хилийн төлөвлөгөөг боловсруулан баталж мөрднө.

ё/эмч ажилчны мэргэжил, мэдлэг, улс төр, эдийн засгийн боловсролыг байнга дээшлүүлэх системтэй ажил зохиож, хүүхдийг асран сувилах, хүмүүхүүлэх арга барилыг байнга дээшлүүлж ажиллана.

ж/үйлчлэх хүрээний хүн амд ариун цэвэр, гэгээрлийн ухуулга сурталчилгааны ажлыг үр дүнтэй зохиож, эмнэлгийн анхны мэдэгдэхүүн олгох, бяцхан иргэдэд ахуйн соёлыг хэвшүүлэх, хадварт өвчнийг бууруулах ажил зохиондо.

з/эмчилгээ сувилгаа болон төлөвлөгөөг ажлын тайлант системийн дээд байгууллагад тогтоосон хугацаанд егэх, эмнэлэг үйлчилгээний тайлант хагас бутэн жилээр гаргаж хөдөлмөрчдөөр хэлэлцүүлэн санал авч ажилдаа үнэлэлт дүгнэлт хийхийн зэрэгшиээ ажилдаа аж ахуйч ажиллагааг нэвтрүүлэн арвилан хэмжэх, ашаралт, багаж хэрэгслэл, тоигүй төхөөрөмжийн ашиглалт, эдэлгээний хугацааг уртасган сайхруулах, энэ ажилд ШБОС, тэргүүт туршилага дэллэрүүлэх ажлыг зохион байгуулж үр дүнг тооцож ажиллах.

ГУРАН. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувиллын эрх

II. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувилал нь дор дурдсан эрхийг эдлэнэ.

а/элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувилалын өрөнхий эмч нь өөрийн эрхийн хэмжээнд тушаал, шийдвэр гаргача.

3.

б/халдварт өвчинтэй тэмцэх, архагшилтаас урьдчилан сэргийлэх, өвчилсний дараа гам сахих ажлыг сайжруулахтай холбогдсон зааварчилга зөвлөмж гаргаж халдвартын эмч, хэсгийн эмч настай ажлаа холбон ажиллах.

в/вируст гепатит өвчний эдгэрэлт, архагшилт эмчилгээ сувилааны талаар онол практикийн бага хурал, зөвлөлгөөн, семинар уулзалтад оролцох, зохион байгуулах.

г/хүүхийн сувилааны эмчилгээ, сувилаа, үйлчилгээ, боловсон хүчин, аж ахуйн үйл ажиллагаатай холбогдсон эрхийг сувилааны эрхлэгч /өрөнхий эмч/ ажил үүргийнхээ хуваарийн дагуудангаараа буюу ҮЭ-ийн хороотой хамгран хэрэгжүүлнэ.

д/сувилааны төсөв орон тооцд тохируулан ажилтан ажилчдыг ажилд авах, халах, сайлаан урамшуулах, дээд байгууллагад тодорхойлох.

е/эрүүлийг хамгаалах яамны даалгавар буюу зөвхөөрсний үндсэн дээр эмнэлгийн шинэ аштарат, багаж төхөөрөмж, эмчилгээ сувилааны шинэ арга хэлбэрийг өөрийн байгууллагад турших, магадлах, үнэлэлт дүгнэлт хийх эрхтэй.

ё/сувилааны үйл ажиллагааны үзүүлэлт, материалыг өрдэм шинжилгээний байгууллага, ажилтанд өгөх ба татгалзах эрхтэй.

з/сувиладд хуваарилагдсан буюу хүсэлтээрээ ирж байгаа мэргэжлийн хүмүүсийг ажил мэргэжлийн шаардлага хангахгүй сахилага дэг журам, хүүхэд асрах, сувилах, хүмүүжүүлэх ажилд тэнцэхгүй гэж үзвэл ажилд аважыг татгалзах, ажилд тохирох хүний нэрийг дэвшүүлэх, мэргэжүүлэх эрхтэй.

э/сувилааны үйл ажиллагаа, эмчилгээ сувилааг сайжруулах асуудал боловсруулж Эрүүлийг хамгаалах газраар дамжуулан Эрүүлийг хамгаалах яаманд санал оруулах.

БИМАУ-ЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ
ЯАМ, УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ 1987 ОНЫ
01/179/238 ТООТ ТУШААЛ, ТОГТООНЫ
2 ДУГААР ХАВРЫН

**УЛААНБААТАР ХОТЫН ЭЛЭГ ЦӨСНИЙ АРХАГ
ӨВЧТЭЙ ХҮҮХДИЙН СУВИЛЫН ҮЙЛ АЖИЛ
ЛАГААНЫ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зохион байгуулалт

1. Тус хүүхдийн сувилал нь 2-15 наасны хүүхдийг сувилах 60 ортой I тасаг, физик эмчилгээ, процедур, элэгний бичлэг хийх кабинет /Реогенато графий/ хулээн авах, лаборатори зэрэг туслах кабинетаас бурдсан I тасаг, захиргаа аж ахуй, гал тогоо, угаалга зэргээс бурдсан I тасаг, бүгд 3 тасагтайгаар зохион байгуулна.

2. Эдгээр таслууд нь өөрсдийн үйл ажиллагааны онцлог, гүйцэтгэх үүрэгт тохирсон заавар, дурмууцийг сувиллын захиргаагаар батлуулан мөрдөж ажиллана.

Хоёр. Сувилалд хүүхэд хулээн авах

1. Элэг, цөсний архаг өвчтэй хүүхдийн сувилалд вируст гепатитын бүрэн биш эдгэрэлттэй, тогтоонги хэлбэрийн архаг гепатит, цироз, ицэвхтэй хэлбэрийн архаг гепатитын чамжмал үе болон вируст гепатитаар өвчилсний дараах австраль эсрэг төрөгч тээгчдийг тус тус хүлээн авч сувилна.

2. Сувилалд сувилуулах хүүхдийг Халдвартын улсын диспансер, эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах эрдэм шинжилгээний улсын нэгдсэн төв, раподын хүүхдийн поликлиникийн эмч нарын зөвлөлгөөний шийдвэрээр тус сувиллаас илгээсэн тоонд багтаан явуулна.

3. Хүүхдийг сувилалд хулээж авахдаа терсний гэрчилгээ, илгээмжийн хуудас, диспансерын хяналтын картыг үндэслэн авна.

4. Хүүхдийн сувилалд шинээр ирэх хүүхдийг долоо хоногийн өдөр бур 10-13 цагийн хооронд хулээн авна.

5. Сувилалд сувилуулах хүүхдийн эцэг эх, хүүхдэд ариун цэврийн хэрэглэл, 2 ээлжийн дотуур хувцас, утлагын хувцас, гэрийн шаахай зэргийг бурдуулж, хүүхдийн хувцас тус бурд өвог нэрийг улаан өнгийн утсаар оёж, 40x60 өм-ийн хэмжээний цагаан уутанд хийж ируулна.

Түрэв. Сувиллаас хүүхэд гаргах журам

1. Тус сувилалд сувилуулсан хүүхдийг ирүүлсэн эмчэлэгт Эрүүлийг хамгаалах яамны сайдын 1971 оны тоот тушаалаар батлагдсан тооцооны 15-р маягтаар хулээлгэж өгнө.

Дөрөв. Эмчилгээ сувилгаа, үйлчилгээний талаар

1. Сувилалд I удаа сувилуулахад биеийн байдалд тохируулан 22-45 хоногоор тогтооно.

2.

2. Сувилуулах шаардлагатай хүүхэд жилд 3-6 сарын завсарлагатай хэд хэдэн удаа давтан сувилуулж болно.

3. Сувилуулж байгаа хүүхдийн эрүүл мэндийг эмч наар долоо хоногт 4-өөс доошгүй узэж хүүхдийн биеийн байдлыг өвчиний картианд тэмдэглэж, сувилгаа, эмчилгээний явцад училсэн дүгнэлт өгч ажлын бусад өдөрт физик эмчилгээ, реабилитация, реогенетографийн кабинетуудад ажиллана.

4. Сувилуулж байгаа хүүхдэд шаардагдах шинжилгээг хийнэ.

5. Тус сувилалд сувилуулж байгаа хүүхдэд узуулэх нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөлгөсний холбогдох эмнэлгүүдээс дуудлагын хуимаар дуудаж зөвлөлгөө авна.

6. Сувилалд байгаа хүүхдээс сөр эмзэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлага гарвал өвчиний нь дагуу нарийн мэргэжлийн больници, хэрэв хүүхдийн эмзэлэгт хэвтэх шаардлагатай бол тус тусын эмнэлэгт шилжүүлнэ.

7. Элэг, цэсний архаг овчтэй хүүхдийн сувилалын эмчилгээ, сувилгаанд хэрэглэгдэж байгаа зуу, ширшиц, багаж хэрэгслийг Халдварт өвчинийг анагаах улсын клиникин төв эмнэлгийн ариутгалын тасагт зохих журмын дагуу ариуттуулж байна.

8. Сувилуулж байгаа хүүхдүүдэд шаардлагатай дусны биохимиин болон ферментийн идэвхийт тодорхойлох шинжилгээг Халдварт өвчинийг анагаах улсын клиникин төв эмнэлэг, иммунологийн шинжилгээг ЭАХНС-ийн институтийн лабораторид тус тус хийлгэнэ.

Тав. Харилцах шалтгаан

1. Вируст гепатитын хурц үе дуусаагүй, мөн илрөхт үедээ байгаа элэг, цэсний архаг овчтэй хүүхдийг авч сувилахгүй.

2. Хавсарсан өвчин нь орчиндоо харилцах иелестэй бол авч сувилахгүй.

3. Вируст гепатитын бус гаралтай элэг, цэсний архаг үрэвсэлтэй хүүхдийг авч сувилахгүй.

4. Халдварт өвчиний хавьтал болсон хүүхдийг хавьталын хугацаа дуустал авч сувилахгүй.